



БЛАН-ӨЛГИЙ АЙМАГ  
ДЭЛҮҮН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 25 өдөр

Дугаар 7/134

Рашаант

2023 оны хоёрдугаар ээлжийн цэрэг  
Татлагыг зохион байгуулах  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Цэргийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4, 12.9, 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалт, Засгийн газрын 2021 оны мн/132 дугаар тогтоол, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2023 оны н/192 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- 2023 оны хоёрдугаар ээлжийн цэрэг татлагыг 2023 оны 10 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулсугай.
- Цэрэг татлагын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.  
Комиссын дарга: С.Аманкелд сумын ЗДТГ-ын дарга  
Нарийн бичгийн дарга: М.Асылбек хэсгийн төлөөлөгч  
Гишүүд: Р.Архалых Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн  
М.Нурсауле Эрүүл мэндийн төвийн дарга  
С.Хуандых ХАА-н тасгийн мэргэжилтэн  
12 багийн Засаг дарга нар
- Цэргийн штабаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу цэрэг татлагын ажлыг зохион байгуулж, хуваарьт өдөр, тогтоосон цагт хүмүүсээ бүрэн хамруулж, цэргийн татлагын үед баг тус бүрээр цэргийн насны залуучуудыг хавсралтын дагуу цэрэг татлагын комисст оруулахыг бүх багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.
- Батлан хамгаалах хууль тогтоомж болон шаардлагатай мэдээ мэдээллүүдийг орон нутгийн ЗДТГ-ын цахим хуудсаар мэдээлэхийг Хууль, эрх зүйн мэргэжилтэн /К.Сандгүл /- д даалгасугай.
- Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын тамгын газрын дарга /С.Аманкелд/-д даалгасугай.

ДАРГА  Б.СЕРИКБОЛ

